



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 09 өдөр

Дугаар A/373

Чингис хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээг  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Захиргааны өрөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу “Тэр өдрийн од” ББН-ий эзэмшлийн Хэрлэн сумын 3 дугаар баг (Баянмөнх), Тэмүүжин гудамжид байрлах, үйлчилгээний зориулалттай 1294 м<sup>2</sup> газрыг иргэн Дүгэрийн Дэжидмаад 45 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.
- Иргэн Д.Дэжидмаа эзэмшил газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.
- Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Баярхүү)-т үүрэг болгосугай.
- Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг Иргэн Д.Дэжидмаад үүрэг болгосугай.
- Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2004 оны А/58 дугаар захирамжийн хэсгийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ



231011839